



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар A/21

Эрдэнэт

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ПҮРЭВЛХАГВА



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН
НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ
ХЯНАЖ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ**

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2025 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
1.1 Аудитын нэр:	4
1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:	4
1.3 Үндэслэл, зорилго:	4
1.4 Хамрах хүрээ:	4
1.5 Арга зүй:	4
ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ	5
2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл	5
2.2 Сонгуулийн зардлын санхүүжилт	5
ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН	5
3.1 Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан	5
3.2 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал	6
ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	6
4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар	6
ТАВ. ДҮГНЭЛТ	6

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Аудитын нэр:

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх.

1.2 Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасны дагуу “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны А/107 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

1.3 Үндэслэл, зорилго:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэн, дүнг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нийтэд мэдээлэхэд оршино.

1.4 Хамрах хүрээ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, аудитын дүгнэлт, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримт, материалуудыг хамрууллаа.

1.5 Арга зүй:

Аудитыг Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг мөрдлөг болгож сонгуулийн зардлын тайланг хянах, нотлох баримтыг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, лавлагаа авах арга зүйг ашигласан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн 1 тойрогт 2 намаас 2 нэр дэвшигч нэр дэвшиж, сонгуульд оролцсон 2 нам сонгуулийн хандив хүлээн аваагүй, зардал гараагүй тул хувийн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгээгүй байна.

Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч зардлын тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлсэн ба орлого төвлөрүүлээгүй, зардал гаргаагүй бөгөөд үлдэгдэлгүй тайлагнажээ.

ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ

2.1 Сонгуулийн зардлын дансны мэдээлэл

Төрийн аудитын байгууллагад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3¹-д заасны дагуу сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг сонгуульд оролцох 2 нам бүртгүүлэхээр заасан хэдий ч Улс төрийн намын тухай хуулийн 26.7-д “Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно” гэж заасны дагуу харилцах дансыг хаасан талаарх мэдээллийг ирүүлж, зардлын тайлан гараагүй байна.

Төрийн аудитын байгууллагад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д заасны дагуу сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийн мэдээллийг 2 нэр дэвшигч ирүүлсэн.

Мөн арилжааны банкнуудаас Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5²-д заасны дагуу нам, эвслийн сонгуулийн зардлын дансны хуулгыг тус тус ирүүлсэн.

2.2 Сонгуулийн зардлын санхүүжилт

Сонгуульд оролцсон намд иргэн, нам, аж ахуйн нэгжээс хандив өгөөгүй байна.

Аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн 2 нэр дэвшигчийн тайлангаар хандив аваагүй, санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлээгүй бөгөөд сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулалт хийгээгүй байна.

ГУРАВ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

3.1 Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 7.9-16.8 сая төгрөгөөр тогтоосон ба нөхөн сонгуульд нам, нэр дэвшигчийн зарцуулах зардлын хэмжээг шинэчлэн тогтоогоогүй болно.

Зардал

¹ 50.3. Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

² 56.5 Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ

Намууд болон нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд зарцуулалт хийгээгүй байна.

Өр төлбөр

Сонгуулийн зардлын тайланд өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4³-д заасан шаардлага хангаагүй нийт 0.1 сая төгрөгийн хандив 1 нэр дэвшигчийн сонгуулийн дансанд төвлөрснөөс 0.1 сая төгрөгийг буцаан шилжүүлсэн байна.

3.2 Сонгуулийн зардлын тайлан баталгаажуулалт, тайлагнал

Төрийн аудитын байгууллагад 2 аудитын хуулийн этгээд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан “ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын дагуу сонгуулийн зардлын тайланг баталгаажуулан ирүүлсэн байна.

ДӨРӨВ. НЭГ САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ИРГЭН, ХОЁР САЯ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨГРӨГИЙН ХАНДИВ ӨГСӨН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

4.1 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1⁴-д зааснаар иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэлх мөнгөн хандивыг сонгуульд оролцсон 2 нам, нэр дэвшигчдэд иргэн, нам, аж ахуйн нэгжээс өгөөгүй байна.

ТАВ. ДҮГНЭЛТ

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшигчдийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хянаж, нэгтгэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- ❖ Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн 1 тойрогт 2 намаас 2 нэр дэвшигч нэр дэвшсэн байна.
- ❖ Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 2 нам сонгуулийн хандив хүлээн аваагүй, зардал гараагүй тул хувийн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгээгүй байна.
- ❖ Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон 2 нэр дэвшигч зардлын тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлсэн ба орлого төвлөрүүлээгүй, зардал гаргаагүй бөгөөд үлдэгдэлгүй тайлагнасан байна.
- ❖ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4-д заасан шаардлага хангаагүй нийт 0.1 сая

³ 53.4.Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

⁴ 53.1.Мөнгөн хандив иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэл байна

төгрөгийн хандив 1 нэр дэвшигчийн сонгуулийн дансанд төвлөрснөөс 0.1 сая төгрөгийг буцаан шилжүүлсэн байна.

- ❖ Иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10 сая төгрөг хүртэлх мөнгөн хандивыг сонгуульд оролцсон 2 нам, нэр дэвшигчдэд иргэн, нам, аж ахуйн нэгжээс өгөөгүй байна.